



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 1/31

Улаанбаатар хот

**Улаанбурхан өвчний тархалтаас
сэргийлэх зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Эрүүл Мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, 20.2.6 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2024 оны “Улаанбурхан өвчний тархалтаас сэргийлэх, зарим арга хэмжээний тухай” 03 дугаар албан даалгаврыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Эмч, эмнэлгийн ажилчдад даалгах нь:

2.1 Эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах чиглэлээр хийх ажлыг зохион байгуулах ажлыг их эмч (О.Номиндалай)-д.

2.2 Эмнэлгийн тусламж үйлчилгээний халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр хийх ажлыг зохион байгуулж, бэлэн байдлыг хангаж ажиллахыг их эмч (Ч.Баасанноров)-д

2.3 Улаанбурхан өвчний тандалтын тархвар судлалын ажлын бэлэн байдал, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг их эмч (Ч.Баасанноров), ахлах сувилагч (О.Удвал) нарт

2.4 Дархлаажуулалтын цахим мэдээллийн санг бүрдүүлэх, дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг дархлаажуулалтын сувилагч (О.Удвал)-д

2.5 Албан даалгаврын хэрэгжилтийг ханган тайлан мэдээг нэгтгэн цаг хугацаанд холбогдох байгууллагад тайлагнаж ажиллахыг Дархлаажуулалтын сувилагч (О.Удвал)-д үүрэг болгосугай.

2.6 Улаанбурхан өвчний бэлэн байдлыг хангахад шаардлагатай эм, тариа хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис, шаардлагатай эд материалын хангалтыг эм найруулагч (Д.Дашдулам), нярав (Б.Энхцэцэг) нарт


3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн ажилтан (Гантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Х.ГАНБАТ

Багахангай Эрүүл мэндийн төвийн даргын
2024 оны 08 дугаар сарын 19 -ны өдрийн
А/3/ тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч	Их эмч	Ч.Баасанноров
Гишүүн	Их эмч	О.Номиндалай
	Их эмч	О.Лхагвацэцэг
	Сувилагч	М.Оюунтүлхүүр
Нарийн бичгийн дарга	Статистикч	О.Удвал